

ГИШҮҮН КОМПАНИЙН СУУДЛЫН ЭРХ ТҮРЭЭСЛҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Монгол Улсын “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 22.5 дахь заалтын дагуу “Монголын хөрөнгийн бирж” ХК /цаашид “Бирж” гэх/-ийн гишүүн нь суудлын эрхээ түрээслүүлэхдээ энэхүү журмыг баримтална.
- 1.2. Гишүүний суудлын эрх /Цаашид “Суудлын эрх” гэх/-ийг түрээсийн гэрээний дагуу эзэмшүүлэгч нь биржийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхтэй брокер, дилерийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд /цаашид “түрээслүүлэгч” гэх/ байна. Суудлын эрх эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй суудлын эрхээ энэхүү журамд заасны дагуу түрээслүүлнэ.
- 1.3. Суудлын эрхийг түрээсийн гэрээний дагуу эзэмшигч, ашиглагч нь биржийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхтэй эсхүл оролцохоор хүсэлт гаргасан брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд /цаашид “түрээслэгч” гэх/ байна.
- 1.4. Түрээслүүлэгч болон түрээслэгч /цаашид “Талууд” гэх/ -ийн хоорондын харилцааг хууль тогтоомж, энэ журамд заасны дагуу байгуулсан түрээсийн гэрээгээр зохицуулна.

ХОЁР. ТАЛУУДАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1 Гэрээнд оролцогч талууд Хорооноос үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ба зөвшөөрөл хүчинтэй байх,
- 2.2 Талууд нь Биржийн гишүүнээр элссэн байх,
- 2.3 Талууд нь Биржтэй байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний үүргээ зөрчөөгүй байх,
- 2.4 Биржид шинээр гишүүнээр элсэх хүсэлтэй түрээслэгчийн хувьд журмын 2.2, 2.3 дахь заалт хамаарахгүй.
- 2.5 Нэг гишүүн нь 2-оос дээш тооны суудал эзэмшихгүй байх,
- 2.6 Биржид хүсэлт гаргахаас 30-аас доошгүй хоногийн өмнө суудал түрээслүүлэх тухай мэдээллийг харилцагчдад бичгээр болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдэгдсэн байх.

ГУРАВ. СУУДЛЫН ЭРХИЙН ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- 3.1 Суудлын эрхийн түрээсийн гэрээг /цаашид “Түрээсийн гэрээ” гэх/ Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журамд нийцүүлэн бичгээр байгуулна.
- 3.2 Түрээсийн гэрээ нь 12 сараас доошгүй хугацаатай байна.
- 3.3 Түрээсийн төлбөрийг хууль болон журамд өөрөөр заагаагүй бол талууд харилцан тохиролцож тогтооно.
- 3.4 Түрээсийн гэрээг байгуулж буй талууд дараах баримтуудыг бүрдүүлж биржид ирүүлнэ. Үүнд:
 - 3.4.1 Талууд суудлын эрхийг түрээслэхийг хүссэн тухай албан бичиг /Түрээслэх болсон үндэслэл, шалтгааныг дурьдсан байх/,
 - 3.4.2 Суудлын эрх түрээслэх тухай компанийн эрх бүхий этгээдийн шийдвэр,
 - 3.4.3 Түрээсийн гэрээ /нотариатаар гэрчлүүлсэн/,

- 3.4.4 Тусгай зөвшөөрлийн хугацаа хүчинтэй эсэх, тусгай зөвшөөрөлд ямар нэгэн хязгаарлалт хийгдсэн эсэх талаар Хорооны тодорхойлолт,
- 3.4.5 Суудал түрээслүүлэх тухай мэдээллийг харилцагчдад мэдэгдсэн талаар мөн харилцагчдаас санал хүсэлт ирсэн эсэх тухай баримт,
- 3.5 Гишүүн нь 3.4-т заасан баримтуудыг бүрэн ирүүлсэн тохиолдолд Биржийн гишүүний бүртгэл хариуцсан алба нь ажлын 7 хоногт багтаан гишүүний суудлын эрхийг түрээслүүлэх эсэх тухай саналаа биржийн Гүйцэтгэх захиралд танилцуулна.
- 3.6 Биржийн гүйцэтгэх захирал гишүүний суудлын эрхийг түрээслүүлэхийг зөвшөөрөх эсэх тухай шийдвэр гаргах ба зөвшөөрсөн тохиолдолд талуудын хооронд байгуулах гэрээг хүчин төгөлдөрт тооцно.
- 3.7 Гэрээний хэрэгжилтийн хугацаанд түрээслүүлэгчийн тусгай зөвшөөрөл хүчингүй болж биржийн гишүүний эрх нь цуцлагдсан тохиолдолд одоогийн түрээслэгч тал нь тэргүүн ээлжинд уг суудлыг авах эрхтэй.
- 3.8 Гүйцэтгэх захирал нь дараах үндэслэлээр суудлыг түрээслэхээс татгалзаж болно. Үүнд:
- 3.8.1 Гишүүний биржтэй байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-гээр хүлээсэн үүргийн хэрэгжилт хангалтгүй,
- 3.8.2 Гишүүн нь биржид хүсэлт гаргаж ирүүлэхээс 6 сарын өмнө Биржийн “Хяналтын журам”-ыг зөрчсөн,
- 3.8.3 Түрээслэгчийн тусгай зөвшөөрөл хүчингүй болсон, эсхүл Хорооноос ямар нэгэн хязгаарлалт хийгдсэн,
- 3.8.4 Шинээр гишүүнээр элсэх хүсэлтэй компанийг биржийн ТУЗ-ийн хурлаас гишүүнээр элсүүлэхээс татгалзсан шийдвэр гарсан,
- 3.8.5 Ирүүлсэн бичиг баримт нь холбогдох хууль болон энэ журамд заасан шаардлагуудыг хангаагүй ба бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн нь нотлогдсон.

ДӨРӨВ. ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭНД ТУСГАГДАХ ЗҮЙЛ

- 4.1. Гишүүдийн хооронд байгуулах түрээсийн гэрээнд дор дурьдсан зүйлийг тусгана. Үүнд:
- 4.1.1 Нийтлэг заалт,
- 4.1.2 Гэрээний үнэ, төлбөр,
- 4.1.3 Төлбөрийн нөхцөл,
- 4.1.4 Гэрээний үргэлжлэх хугацаа,
- 4.1.5 Талуудын эрх үүрэг,
- 4.1.7 Талуудын хүлээх хариуцлага,
- 4.1.9 Бусад / Маргаан шийдвэрлэх, Давагдашгүй хүчин зүйл, Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах гэх мэт/

ТАВ. БУСАД

- 5.1 Түрээслүүлэгч болон түрээслэгч нь биржтэй байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний үүргээ гүйцэтгэж ажиллана. Түрээслүүлэгч нь гишүүний суудлын эрхээ түрээслүүлсэн нь биржийн өмнө хүлээх хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.
- 5.2 Түрээслэгч компани нь үнэт цаасны арилжаанд оролцохдоо биржээс гишүүнд олгосон арилжааны программд хандах өөрийн эрх, кодыг ашиглана.
- 5.3 Хэрэв гишүүн нь журмын 3.6-д заасан Гүйцэтгэх захирлын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол энэ тухай гомдлоо эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлж болно.
- 5.4 Түрээсийн гэрээний биелэлтэд талууд харилцан хяналт тавина. Гэрээний үүргээ зөрчснөөс талуудын аль нэгэнд учирсан хохирлыг бирж хариуцахгүй.
